



МОНГОЛ УЛСЫН
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ
ТОГТООЛ

2021 оны 6 сарын 04 өдөр

Дугаар 23

Улаанбаатар хот

**Санал авах байранд тавигдах ерөнхий шаардлага,
санал авах байр бэлтгэх заавар батлах тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.9 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.9 дэх хэсэг, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.9 дэх хэсэг, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1.“Санал авах байранд тавигдах ерөнхий шаардлага”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Санал авах байр бэлтгэх заавар”-ыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэхүү зааврыг мөрдөж ажиллахыг сум, дүүргийн Засаг дарга, сонгуулийн хороодын дарга нарт, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Сонгуулийн ерөнхий хорооны нарийн бичгийн дарга /Д.Даваа-Очир/-д тус тус даалгасугай.

3.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны 2020 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн “Санал авах байрыг бэлтгэх заавар батлах тухай” 45 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА




П.ДЭЛГЭРНАРАН

Д.ДАВАА-ОЧИР

00000045

Сонгуулийн ерөнхий хорооны
2021 оны 3 дугаар сарын 04 ны өдрийн
23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт



САНАЛ АВАХ БАЙРАНД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

1.Хамрах хүрээ

Энэхүү ерөнхий шаардлагаар санал авах байранд тавигдах ерөнхий шаардлагыг тогтооно.

2.Хууль эрх зүйн болон техникийн үндэслэл

Энэхүү ерөнхий шаардлага нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.2 дахь хэсэг, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.2 дахь хэсэг, Ард нийтийн санал асуулгын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсэг, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалт болон дараах стандартыг мөрдлөг болгоно.

1.MNS 6055:2009, Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин. Үндсэн шаардлага,

2.MNS 6056:2009, Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар

3.Нэр томъёо, тодорхойлолт

“Санал авах байр” гэж Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль, Монгол Улсын Их Хурлын сонгууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль, Ард нийтийн санал асуулгаар сонгогчдоос санал авах ажиллагааг зохион байгуулах объект.

4.Санал авах байранд тавигдах ерөнхий шаардлага

4.1.Санал авах байрын гадна орчинд тавигдах шаардлага.

4.1.1.Санал авах байрны гадна орчин явган болон тэргэнцэртэй иргэн зорчиход саадгүй байх, хэрэв саад үүссэн бол санал авах өдрөөс өмнө тухайн асуудлыг шийдвэрлэх боломжтой байх;

4.1.2.Санал авах байрны гадна талд хаяг, мэдээллийн самбарыг нийтэд хүртээмжтэй байдлаар байрлуулах /харааны бэрхшээлтэй иргэд, өндөр настан болон олон нийтэд зориулсан мэдээ, мэдээллийг болон хаягийг тод харагдахуйц том үсгээр хэвлэн байршуулах/;

4.1.3.Санал авах байр нь тэргэнцэртэй иргэн өөрөө орж гарах нөхцөл бололцоотой байх, орц гарц нь босготой бол тэргэнцэртэй иргэнд тохиромжтой байдлаар шийдэх;

4.1.4.Санал авах байрны гадна талын үүдэн хэсгийн шал, шат нь иргэд хальтирч гулгах эрсдэлгүй байх /гялгар плита, шалтай бол хальтирч гулгахааргүй материалаар хамгаалалт хийх/;

4.1.5.Санал авах байрны гадна орчны гэрэлтүүлэг сайтай байх;

4.1.6. Хүн хоорондын зай баримтлан суух боломжтой хүлээлгийн сандал байрлуулах;

4.1.7. Гадны орчныг ажиглах хяналтын камертай байх, хяналтын камергүй бол ажиглагчид, хэв журам сахиулж буй цагдаагийн алба хаагчид байрны гадна орчинг ажиглах, хяналт тавих бололцоотой байх.

4.2. Санал авах байрын дотор орчинд тавигдах шаардлага.

4.2.1. Өндөр настан болон тэргэнцэртэй иргэд орж гарахад саадгүй, босгогүй байх, босготой тохиолдолд налуу байх;

4.2.2. Санал авах байранд хүн хоорондын зай баримтлан зогсох боломжтой байх, мөн зай баримтлан суух хүлээлгийн сандал байрлуулах;

4.2.3. Сонгуулийн хороодын бүрэлдэхүүн, эрүүл мэндийн болон онцгой байдал, мэргэжлийн хяналтын зэрэг байгууллагаас нэмэлтээр ажиллах төрийн албан хаагчид ажиллах, сонгогчдын ачааллаас хамаарч санал авах ажиллагааг тасралтгүй явуулах бололцоо бүхий хангалттай зай талбайтай танхимтай байх;

4.2.4. Цэвэрлэгээ, үйлчилгээ, ариутгалыг тогтмол хийх, агааржуулалтыг сэлгэх боломжтой, үер усны болон бусад гэнэтийн аюулаас сэргийлсэн аюулгүй байр сонгох;

4.2.5. Хяналтын камерыг сонгогч санал өгөх үйл явцад саад болохгүй, сонгогчийн саналын нууцлалыг хангасан байрлалд байрлуулсан байх.

4.3. Санал авах байрны ашиглалтын талбай нь дараах хэмжээнээс багагүй байна:

4.3.1. Аймгийн төв, дүүрэгт – 80мкв

4.3.2 Сумын төвд – 60мкв

4.3.3 Баг – 20мкв

5. Санал авах байрын дотоод зохион байгуулалтад тавигдах ерөнхий шаардлага

5.1. Санал авах байрны дотор танхимын орц гарцыг нэг урсгалтай байхаар зохион байгуулах боломжтой байх;

5.2. санал авах байрны дотоод зохион байгуулалт нь сонгогчдод ойлгомжтой байх, санал авах үйл явц ажиглагчдад бүхэлдээ харагдахуйц байхаар зохион байгуулах;

5.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан тусгайлан тоногдсон нэгээс доошгүй тооны санал бэлтгэх бүхээгийг зайлшгүй бэлтгэсэн байх;


5.4. Сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулах, санал авах ажиллагааны явцад халдварт өвчний сэжигтэй тохиолдол илэрсэн тохиолдолд сэжигтэй тохиолдлыг тусгаарлах өрөө тасалгаа бэлтгэх боломжтой байх;

6. Санал авах байрын аюулгүй байдалд тавигдах ерөнхий шаардлага

6.1. Санал авах байрын галын аюулгүй ажиллагааг хангаж, авралтын зам, гарцын зураглал болон гал унтраах анхан шатны багаж, хэрэгсэлтэй байна.

6.2. Аюулгүй байдлын зориулалтаар хяналтын камертай байна.

Сонгуулийн ерөнхий хорооны
2021 оны 3-дугаар сарын 24-ны өдрийн
23-дугаар тогтоолын 2 дугаар хавсралт



САНАЛ АВАХ БАЙР БЭЛТГЭХ ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Санал авах байр бэлтгэхэд сонгуулийн тухай хууль тогтоомж, санал авах байранд тавигдах ерөнхий шаардлага болон энэхүү зааврыг мөрдлөг болгоно.

1.2. Санал авах байранд тавигдах ерөнхий шаардлагын 4-р зүйлд заасан шаардлага хангасан санал авах байрыг төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд үнэ төлбөргүй ашиглуулна.

Хоёр. Санал авах байрыг бэлтгэх

2.1. Сум, дүүргийн Засаг дарга санал авах өдрөөс долоогоос доошгүй хоногийн өмнө санал авах байранд тавигдах ерөнхий шаардлагын 5-р зүйлд заасан дотоод зохион байгуулалтад тавигдах ерөнхий шаардлага хангасан санал авах байрыг бэлтгэж, хэсгийн хороонд хүлээлгэн өгнө.

2.2. Санал авах байранд дараах зүйлсийг бэлтгэсэн байна:

2.2.1. Төрийн далбаа;

2.2.2. сонгогч саналаа нууцаар өгөхөд шаардагдах хоёроос доошгүй бүхээг;

2.2.3. зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх сонгогч саналаа нууцаар өгөхөд шаардагдах бүхээг;

2.2.4. суурин болон зөөврийн битүүмжилсэн саналын хайрцаг;

2.2.5. сонгогчийн бүртгэлийн мэдээллийг ажиглагчид үзүүлэх дэлгэц;

2.2.6. харааны бэрхшээлтэй сонгогч саналаа өгөхөд зориулсан саналын хуудсыг унших, саналаа тэмдэглэх тусгай зориулалтын брайль үсэг бүхий хавтас, томруулдаг шил;

2.2.7. саналын хуудаст саналаа хэрхэн тэмдэглэх тухай заавар;

2.2.8. саналын хуудаст санал тэмдэглэх зориулалтын үзэг;

2.2.9. хэсгийн хорооны бүрэлдэхүүн болон мэдээллийн технологийн даамал, улсын бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтан ажиллахад хүрэлцэхүйц тооны ширээ, сандал, утас, факс, компьютер, принтер;

2.2.10. цахилгаан эрчим хүчний эх үүсвэрт холбогдоогүй хэсэгт цахилгаан үүсгүүр;

2.2.11. ажиглагчдын ширээ, сандал;

2.2.12. саналын хуудсыг хадгалах сэйф, лацны тэмдэг;

2.2.13. мэргэжлийн байгууллагын зөвлөмжид заасан халдвар хамгаалал, ариутгалын хэрэгсэл.

2.2.14. хууль тогтоомжид заасан бусад.

2.3. Санал авах байр бүрт хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан нэгээс доошгүй санал бэлтгэх бүхээгийг тусгайлан тоноглож бэлтгэсэн байна.

2.4. Санал авах байранд тавигдах ерөнхий шаардлагын 6-р зүйлд заасан аюулгүй байдалд тавигдах ерөнхий шаардлагыг дараах байдлаар хангана.

2.4.1. Санал авах байрны хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангах зорилгоор санал авах байруудад хяналтын камер;

2.4.2.Санал авах байрын галын аюулгүй ажиллагааг хангаж, авралтын зам, гарцын зураглал болон гал унтраах анхан шатны багаж, хэрэгсэл.

2.5.Энэ зааврын 2.4.1-д заасан хяналтын камерыг байрлуулахад Сонгуулийн ерөнхий хороо, Цагдаагийн ерөнхий газрын даргын хамтарсан тогтоол/тушаалаар батлагдсан “Санал авах байранд байрлуулах хяналтын камерт тавигдах шаардлага, түүнийг байрлуулах, ашиглах болон бичлэгийг хадгалах, хамгаалах, устгах журам”-ыг баримтална.

2.6.Энэ зааврын 2.4.2-д заасан багаж хэрэгсэл байрлуулахад Засгийн газрын 2016 оны 339-р тогтоолоор батлагдсан “Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм”-ын 8-р зүйлд заасныг баримтална.

2.7.Санал авах байрны гадна Монгол Улсын Төрийн далбааг байрлуулж, “..... сонгуулийн (аймаг, сум, дүүрэг/тойргийн) дугаар хэсгийн санал авах байр” гэсэн хаягтай байна.

Гурав. Санал авах байрны эрүүл ахуй, аюулгүй байдал

3.1.Санал авах байранд санал тоолох төхөөрөмж, сонгогчийн бүртгэлийн техник хэрэгсэл болон саналын хуудас хүлээн авснаас хойш тухайн санал авах байрыг цагдаагийн хамгаалалтад авна.

3.2.Санал авах байрны харуул хамгаалалт, аюулгүй байдлыг сонгуулийн хороод, тухайн шатны Засаг дарга, цагдаагийн байгууллага, онцгой байдлын алба хариуцан гал, усны зэрэг гэнэтийн болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах ажлыг зохион байгуулна.

3.3.Санал авах байрны зохион байгуулалт, ариутгал, халдваргүйжүүлэлтийг мэргэжлийн байгууллагын зөвлөмжийн дагуу тухайн шатны Засаг дарга мэргэжлийн байгууллагатай хамтран хийж гүйцэтгэнэ.

3.4.Санал авах байрыг нийтийн эмх замбараагүй байдал, үер ус, гал түймэр зэрэг давагдашгүй хүчин зүйлийн улмаас өөрчилж болох бөгөөд энэ тухай нэн даруй сонгогчдод мэдэгдэнэ.